

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалын холбох үгЦэндийн БАТТУЛГА¹Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Их Сургууль,
Хүмүүнлэгийн ухааны салбар, Ази судлалын тэнхим**Submitted:** September 25, 2025 | **Accepted:** December 26, 2025

Хураангуй: Эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалын үг, өгүүлбэр, өгүүлбэрийн гишүүд болон салангид өгүүлбэрийг дэс дараатай, тогтолцоотой ойлгож, утгын харилцан хамаарлыг тогтооход холбох үг чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Холбох үг гэрэлт хөшөө, хад чулууны бичээст ямар утга, үүрэгтэйгээр хэрэглэгдэж байгааг хэрхэн ойлгож, орчуулснаас дурсгалын утга, агуулга ихээхэн хамаардаг. Үүний учир, эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалын холбох үгийн үүрэг, хэрэглээг жишээгээр тодруулан өгүүлэхийг зорив.

Түлхүүр үг: Эртний түрэг хэл, руни бичиг, сонгодог дурсгал, холбох үг

Old Turkic conjunctions in classical runic inscriptions

BATTULGA Tsend

*Department of Asian Studies, School of Humanities,
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: Through the approach of a methodical examination of textual examples, this article investigates the meanings, functions, and usage patterns of conjunctions that are found in classical Old Turkic runic inscriptions. For the purpose of this study, a functional and discourse-oriented methodology is utilized. Conjunctions are analyzed not only as grammatical connectors of sentence components and phrases, but also as instruments that structure narrative progression and build logical relationships within the texts.

Keywords: Old Turkic language, runic script, classical inscriptions, conjunctions

¹ © Ц.Баттулга, 2025

Email: tulga@num.edu.mn

1. Удиртгал

Монголын төв нутаг, Орхоны хөндийгөөс 1889 онд Оросын Газар зүйн нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын шинжилгээний анги (Ядринцев 1892, 1901) руни бичиг бүхий гэрэлт хөшөө, дурсгалуудыг илрүүлсний мөрөөр 1890 онд Фин-Угорын шинжилгээний анги (Heikel et al. 1892), 1891 онд Оросын шинжилгээний анги (Радлов 1892a, 1892b, 1894b, 1894c) тус тус ирж руни бичгийн дурсгалын гэрэл зураг, хэв дардас авах зэргээр судалгааны баялаг эх хэрэглэгдэхүүн цуглуулж судлан шинжилснээр эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалын хэлний судалгаа эхэлсэн хэмээн үзэж болно.

XIX зууны сүүл, XX зууны эхэн үеэс Орос, Герман, Япон, Их Британи, Франц зэрэг улсын хээрийн шинжилгээний анги Дорнод Түркестан Турфан, Дунханы агуйн гайхамшигт дурсгалууд, Хар хотын номын сангийн үлдэл болох олон хэл, үсэг бичгээрх ном судрыг нээн илрүүлснээр түрэг хэлний руни, уйгур, согд, брахма, манихей, сири зэрэг үсэг бичгээрх хангалтай эх хэрэглэгдэхүүн хуримтлагдаж, тэдгээр сурвалжийн баримтад тулгуурлан эртний түрэг хэлний судалгаа улам өргөжин гүнзгийрэх нөхцөл бүрджээ.

Өөрөөр хэлбэл, олон зүйл үсэг бичгийг тайлан уншиж утга агуулга, холбогдох он цаг, хамаарах түүхэн үйл явдлыг тогтоон тодотгох түүхэн сурвалж судлалын судалгааны зэрэгцээ тэдгээр сурвалжийн хэлийг хэл шинжлэлийн үүднээс тухайлан судалж эхэлсэн байна. Аливаа хэлийг хэл шинжлэлийн үүднээс судлахдаа баримталсан онол, арга зүйгээс хамаарч судалгааны үр дүн харилцан адилгүй байх тохиолдол буй. Үүний учир, хэл шинжлэлийн ямар онол, арга зүйг баримталж тухайн хэлний сурвалжийг судалсан болохыг эрхбиш анхааран үзэх зайлшгүй шаардлагатай.

Залгамал бүтэц бүхий нийтлэг хэв шинжээрээ Алтайн хэлний бүлэгт хамаарах монгол, түрэг хэлний судалгаанд дорнын болон өрнийн хэл шинжлэлийн онолын судалгааны аль аль нь чухал байр суурь эзэлдэг.

Хэлний зүй тогтлыг судлахын тулд үгсийг хэл зүй, утга зүйн төсөөт шинжээр нь нэр үг, үйл үг, угтвар үг, чимэх үг гэж анх ангилсан эртний Энэтхэгийн хэл зүйч Яскагаас эхлэлтэй үгийг аймаглах дорнын хэл шинжлэлийн уламжлал өдгөө ч байсаар байгаа билээ.

Эртний Грекийн нэрт сэтгэгч Платон “өгүүлбэр нь үйл үг (*рэма*), нэр үг (*онама*) хоёрын нийлцээс бүтнэ” гэсэн бол Аристотель үйл үг, нэр үгээс гадна холбох үг (*синдэсмос*) чухал үүрэгтэй гэжээ. Холбох үг гэдэгт өнөөгийн хэл шинжлэлд холбох үг гэж тодорхойлогдсон үгээс гадна төлөөний үг, угтвар үг, ялгац үг зэргийг багтаажээ (МХС, Үг зүй, 2022: 63). Энэхүү ангилал Ром-Европын буюу өрнийн хэл шинжлэлийн уламжлал болж хөгжсөн түүхтэй.

Үгсийн ижил төстэй болон ялгарах шинж чанарыг хэрхэн тодорхойлж байгаагаас хамаарч үгийг аймаглах нь зарчмаараа ялгаатай үгийн сан- утга зүйн, үгийн сан-хэл зүйн, хэлбэр-хэл зүйн гэсэн гурван үндсэн чиглэлд хуваагддаг бөгөөд дээрх гурван зарчим бүгд өөр өөрийн гэсэн давуу ба сул талтай учраас аль нэгийг дангаар баримтлалгүй, ангиллын тодорхой түвшинд аль зохицох

зарчмыг нь сонгон, ижил тэгш харгалзан үзвээс үнэнд илүү ойр, цэгцтэй тогтолцоог бүрдүүлэх боломжтой (МХС, Үг зүй, 2022: 64) гэж үздэг байна.

Алтайн хэлний бүлэгт багтах түрэг, монгол хэлний үгийг аймаглах зарчим ерөнхийдөө ижил төстэй бөгөөд түрэг хэлний үгсийг өрнийн хэл шинжлэлийн уламжлалаар ангилж, судалсаар иржээ.

Эртний түрэг хэлний сурвалжид Түрэг, Уйгур улсын үеийн руни бичгийн дурсгалууд, уйгур хэл бичгээрх хууль цаазын бичгүүд болон Алтан гэрэл (*Altun Yaruq*), Найман гэгээн (*Sekiz Yükmek*) зэрэг бурхны шашны судар номын орчуулга, манихей, согд, брахма зэрэг бичгээрх гар бичмэл, Харханидийн үеийн уйгур бичгээрх Ерөөлт билиг буюу Ерөөл билгийн сургаал (*Qutadqu bilig*) зэрэг сургаалын зохиол багтах бөгөөд бид энэхүү өгүүлэлдээ эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалын холбох үгийн тухайлан авч үзэхийг хичээлээ.

Холбох үг нь “Туслах үг”- д хамаарах ба туслах үгийн хэлэнд гүйцэтгэж буй үүргээр нь холбох үг (*conjunctive words*), баймж үг (*modal words*) гэж ангилдаг билээ.

Туслах үг гэдэг нь үгийн сангийн бие даасан утгагүй, хэл зүйн хувиллаар үл хувилдаг, өгүүлбэрт бие даан гишүүн болдоггүй зөвхөн үг, өгүүлбэрийг холбох, тэдгээрийн утгыг төрөл бүрийн баймж утгаар чимж дэлгэрүүлэх үүрэг бүхий бүлэг үгс (МХС, Үг зүй, 2022: 174) бөгөөд өгүүлбэр болон өгүүлбэрийн гишүүдийг хооронд нь холбон эмхэлж, зохион байгуулдаг тул туслах үгийн үүргийг өгүүлбэрийн бүтцээс салангид тодорхойлох боломжгүй юм.

Тиймээс салангид өгүүлбэр болон өгүүлбэрийн гишүүдийг холбох үүрэгтэй үгийг хэл шинжлэлд холбох үг (*conjunctive words*) гэх ба үүрэг, харьцаа заах шинжээр нь зэрэгцүүлэн холбох үг, захируулан (угсруулан) холбох үг гэж ангилдаг.

Түрэг хэлний холбох үгийг цаг хугацаагаар нь эртний түрэг хэлний холбох үг, дундад үеийн буюу Осман хэлний холбох үг, орчин цагийн турк (түрк) хэлний холбох үг гэж хуваан судалж болох ба энэ удаад, эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалын холбох үгийн талаар өгүүлэхийг зорив. Үүний тулд, эхлээд эртний түрэг хэлний холбох үгийн талаарх судалгаанаас дурдъя.

Германы эрдэмтэн А.фон.Габэн “Эртний түрэг хэлний хэл зүй (*Alttürkische Grammatik*)”-н бүтээлдээ хамгийн анх удаа эртний түрэг хэлний үгийг ангилахдаа “Нэр үг, төлөөний үг, тооны нэрийн араас орж, тэдгээртэй нягт холбоотой байж, утгын хувьд захирагддаг боловч дүрмийн хувьд тэдгээрийг зохицуулах үүрэг бүхий үгсийг дагавар үг (*Postpositionen*)” гэж тодорхойлжээ.

Турфанаас илрүүлсэн ном судрын эх хэрэглэгдэхүүнд тулгуурласан уг судалгааны бүтээлд дагавар үгийн өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг, илрүүлэх утга, -*u*, -*a*, -*i* нөхцөлөөр үүссэн нөхцөлт үйл үг (*Konverba auf -u, -a, i*); -*o**n* нөхцөлөөр үүссэн нөхцөлт үйл үг (*Konverba auf -o**n*); -*o**p*, -*o**pan* нөхцөлөөр үүссэн нөхцөлт үйл (*Konverba auf -o**p* und *o**pan*) гэж ангилаад ихэвчлэн зорилго, шалтгаан, орон байр, тоо хэмжээ заадаг болохыг тэмдэглэжээ (Gabain, 1950 :135-143).

Ахмет Темир 1956 онд уйгур бичгийн дурсгалууд, тухайлбал Турфаны цуглуулга дахь уйгур хэл бичгээрх сурвалжид тулгуурлан *azu*, *amti* ‘одоо, тийм бол, тийн бөгөөс’, *amti yana* ‘одоо бас’, *amti yme*, *ančula*, *ančulayu* ‘тийн, одоо, дахин’, *ančula yme* ‘мөн тийн, тийнхүү бас’, *anta basa* ‘тэгээд бас, түүний дараа, дараа нь’, *anta kin*, *anta kisre* ‘түүний дараа, түүнээс хойш’, *antada basa*, *ap yme* ...

ap yme ‘түүний зэрэгцээ, түүнчлэн, ... ч гэсэн’, *birök* ‘одоо, харин, тэгвэл’, *inče kaltu* ‘өөрөөр хэлбэл, түүнчлэн’, *inčip* ‘гэхдээ, эсвэл’, *kaltu* ‘... ч, ... л’, *ötkürü* ‘...-аас шалтгаалж, -аас болж, түүнээс хойш, түүнээс нааш’, *ötrü* ‘хойно, дараа, сүүлд, ард нь’, *kayu yme* ‘тэгээд бас, тэгээд дахин, дахин ахин’, *udu* ‘дараа, хойно’, *ulatu* ‘болон, бусад’, *yana* ‘мөн, дахин, дахиад’ (Temir, 1956: 41-85) зэрэг холбох үг тохиолдож байна гэж үзжээ.

БНТУ-ын эрдэмтэн Талат Текин 1968 онд “*A Grammer of Orkhon Turkic*” ном хэвлүүлсэн нь Түрэгийн хожуу хаант улсын үед холбогдох Күлтигин, Билгэ хаан, Туңьюкук, Онги, Күличурын гэрэлт хөшөөний руни бичгийн дурсгалын хэлний хэл зүйг тусгайлан судалсан анхны нэгэн сэдэвт бүтээлд зүй ёсоор тооцогддог билээ. Тус номд руни бичгийн дурсгалын холбох үгийг *Coordination without Conjunction*- холбох үггүй холбох, *Coordination with Conjunction*-холбох үгээр холбох гэж ангилаад *azu* ‘ба, буюу’, *artuqi* ‘илүү, илүү их, хэт их, хэтийдсэн’, *yime* ‘ба, -ч, бас’, *biriki, taqi, udu, ulayu* ‘ба’ гэх холбох үгс тохиолдож буйг тэмдэглэсэн байна (Tekin, 1968: 210-211).

Тэрээр хожим хэвлүүлсэн “Орхоны түрэг хэлний хэл зүй (*Orhon Türkçesi Grameri*)” номдоо Орхоны түрэг хэлэнд *ara, birlä, ingaru, kisrä, kudi, ötrü, sayu, tara, täg, üçün, üzä, eyin, tägi, adın, öñi, ingaru* гэх дагавар үг (*sontakilar*); *azu, artuki, taki, udu, ulayu, yätmä* гэх зэрэгцүүлэн холбох үг (*sıradas bağlaçlar*); *üçün, tiyin, tip* гэх захируулан холбох үг (*yan cümle bağlaçlar*) тохиолдож буйг холбогдох жишээ дурдаж тэмдэглэжээ. Мөн *üçün* ‘тул, учир’ гэх үг дагавар үг бас холбох үгийн үүрэгтэй болохыг дурдсан байна (Tekin, 2000: 156-159).

Тухайн үеийн Зөвлөлт холбоот улсын эрдэмтдээс Г.Айдаров “*Язык Орхонских памятников древнетюркской письменности VIII века*” номдоо “Туслах үг (*служебные части речи*)” хэсэгт Орхон бичгийн дурсгалд дагавар үг (*послелог*), холбох үг (*союзы*), сул үг (*частицы*) цөөнгүй тохиолдож буйг тэмдэглээд 𐰽𐰺 *meğ* – подобный, как, похоже, 𐰽𐰺 *meği-* до, вплоть, 𐰽𐰺 , 𐰽𐰺 *үчүн-* для, ради, вследствие, 𐰽𐰺 *үтү-* поэтому, оттого, после того, 𐰽𐰺 *бирле-* с, вместе, 𐰽𐰺 *tana* – как, по направлению, 𐰽𐰺 *кесре, кісре-* после, затем, аг *ара-* между, среди, 𐰽𐰺 *аша-* через, за, 𐰽𐰺 *сайу-* по, вдоль гэх үгсийг дагавар үг (*послелог*), 𐰽𐰺 *йеме-* и, также, еще, 𐰽𐰺 , 𐰽𐰺 , 𐰽𐰺 , 𐰽𐰺 *та, те, да,* де-ийг холбох үг (*союзы*), *йалнус-* один, только, лишь, 𐰽𐰺 *күк-* частица предположения, 𐰽𐰺 *йана-* опять, еще, 𐰽𐰺 *му, мү, мы, ми-* ли-ийг сул үг (*частицы*) (Айдаров, 1971: 233-237) гэж үзсэн байна.

В.Г.Кондратьев “*Грамматический строй языка древнетюркской письменности VIII-XI вв*” номдоо холбох үгийн талаар цухас төдий дурджээ (Кондратьев, 1981: 131-134).

М.Ердал “*A Grammar of Old Turkic*” номынхоо “3.33. *Conjunctions*” хэсэгт эртний түрэг хэлний холбох үгсийг Турфаны цуглуулга, Ирк битиг зэрэг ихэвчлэн бичмэл сурвалжийн жишээ баримтад тулгуурлан судалснаас гадна руни бичгийн сонгодог дурсгалын жишээ баримтаас ч дурджээ. Тус судалгаанд эртний түрэг хэлний онцлогийг тухайлан дурдаад, *birök, yätmä, yana, azu, ančip, inčip, udu* зэрэг холбох үгсийн бүтэц, өгүүлбэрүүд болон өгүүлбэрийн гишүүдийг холбох үүрэг, харьцааг нарийвчлан авч үзсэн байна.

Эртний түрэг хэлний холбох үүрэг бүхий үгийн тогтолцоо нь нэн баялаг бөгөөд үг, өгүүлбэр, өгүүлбэрийн гишүүдийн логик-утга зүйн харьцааг

илэрхийлэхэд туслах үг чухал үүрэг гүйцэтгэж буйг тэмдэглэжээ. Жишээ дурдан тайлбарласнаас заримыг дурдвал: *yana* холбох үг нь *yan-* ‘буцах’ гэсэн үйл үгээс үүсэлтэй. Орхоны руни бичгийн дурсгалд *yana* гэж арын эгшгийг тодорхой тэмдэглэсэн бол уйгур хэлэнд *yänä*, *yenä* болж хувирсан байна. Жишээлбэл *yänä ök* хэлбэр нь эгшгийн зохицлыг харуулна. *yana* ‘дахин’ гэсэн утгатай дайвар үг бөгөөд холбох үүрэг нь давамгайлсаар ‘цаашлаад, түүнчлэн’ гэсэн утгатай болж улмаар *yenä ök*, *yenä ymä* гэж хоршин холбох үгийн үүрэг гүйцэтгэх болжээ.

azu ‘эсвэл’ гэх холбох үг. Күлтигиний гэрэлт хөшөөний өмнө талын 10-р мөрд “*azu bo savimda igid bar gu? -Or is there anything false in these my words?* (Эсвэл энэ үгэнд минь худал байна уу?)” гэж тохиолдоно. Турфаны дурсгалд хоёр өгүүлбэрийг *azu azu* ‘эсвэл ... эсвэл’ гэж зэрэгцүүлэн холбосон ба *azu* нь *az-* ‘төөр-’ үйл язгуураас бус *aza* хэлбэрээс *azuča*, *azusinta*, *azuki* үүссэн гэжээ.

ancip ‘ингээд, тэгээд, тийнхүү’ холбох үг. Руни бичгийн дурсгалын *ancip* болон Уйгурын бичгийн *incip* гэх үгс гарал нэг юм. *ancip* холбох үг өгүүлбэрийн эхэнд, мөн *-dl* эсвэл *-mlš*-ийн дараа байрлах ба *ancip*, *incip* хоёр ижил утгатай үг гээд Турфаны уйгур, манихей бичгийн сурвалжид *incip* нь ‘адил, адилхан’, бас ‘учир нь’ гэсэн утгаар мөн тохиолдоно гэжээ. Тэрээр эртний түрэг хэлний *taki*, *yana*, *azu*, *ap*, *kim*, *apam*, *ärkän/ärkli*, *ötrö*, *udu*, *kalti*, *incip* зэрэг үгс нь хэл зүйн хувьд утга гарал өөр өөр боловч бүгд өгүүлбэр холбох, утгын нь гүнзгийрүүлэн тодруулах нийтлэг үүрэгтэй бөгөөд эдгээрээс *taki*, *azu*, *kim* жинхэнэ холбох үүрэгтэй бол, *kalti*, *ötrö*, *incip*, *apam* зэрэг үгс хэрэглээний явцад холбох үүрэгтэй болсон гэж үзжээ (Ердал, 2004: 337-342).

БНТУ-ын эрдэмтдээс А.Ержиласун “Эртнээс хорьдугаар зуун хүртэлх түрэг хэлний түүх (*Başlangıçtan Yirminci Yüzyıla Türk Dili Tarihi*)” хэмээх номдоо эртний түрэг хэлэнд *başlayu*, *ulayu*, *artuqi*, *taki*, *yeme*, *udu azu* гэх холбох үг, *ok ~ök~ kök*, *mu ~gu*, *birle*, *üçün*, *teg*, *ara*, *kodi*, *sayu*, *tapa*, *tiyin~ tip*, *tegi üze*, *örtü* баймж үг байжээ (Ercilasun, 2004: 193) хэмээн тэмдэглэсэн байна.

Хатижа Ширин “Эртний түрэг бичээсүүд. -Үгийн сангийн судалгаа (*Eski Türk Yazıtları. Söz Varlığı İncelemesi*)” хэмээх нэг сэдэвт судалгааны бүтээлдээ эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалд *artuka*, *aşnuka*, *azu*, *başlayu*, *birlä*, *taki*, *tip*, *tiyin /teyin*, *udu*, *ulayu*, *yämä* гэсэн холбох үг тохиолдож байна гэж үзжээ (Şirin, 2016: 296-300).

Дээр дурдсан эрдэмтдийн судалгаанаас гадна эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалын холбох үгийн судалгаанд шууд хамаарах эрдэм шинжилгээний өгүүлэл харьцангуй цөөн ажээ.

Түрэг угсаат ард түмний дунд IX зууны сүүл үеэс дэлгэрсэн исламын шашин, соёлын нөлөөгөөр түрэг хэл, аялгуунуудад, ялангуяа Огуз бүлгийн хэл, аялгуунд араб, перс хэлний үгс нэвтэрч, улмаар уугуул түрэг язгуурт холбох үгс аажимдаа цөөрч харь хэлний холбох үгс зонхилох болжээ.

Үүний учир исламын шашны дэлгэрэлтээс хойших үеийн түрэг хэлний холбох үгийг, тодруулбал осман (*osman*) хэл, орчин цагийн турк (түрк) хэлний холбох үгсийг гарлынх нь хувьд түрэг язгуурт холбох үг, харь гаралтай холбох үг, холимог гаралтай холбох үг гэж хуваадаг байна. Харь гаралтай холбох үгийг араб хэлнээс орсон, перс хэлнээс орсон гэж хоёр ангилах ба холимог гаралтай холбох үгст араб - перс, перс - араб, араб - турк, перс - турк, араб - перс - турк

үгс нийлж бүтсэн нийлмэл бүтэц бүхий холбох үгсийг хамруулдаг болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг (Korkmaz, 2003: 1094-1095). Энэ далимд, Зейнеп Кокмаз “Орчин цагийн турк хэлний хэл зүй. Бүтээвэр зүй (*Türkiye Türkçesi Grameri. Şekil Bilgisi*)” бүтээлдээ орчин цагийн турк хэлний холбох үгийг ангилж, үүрэг, утга, хэрэглээний нарийн ялгамж, ялгааг тухайлан судалсан (Korkmaz, 2003: 1094-1136) болохыг дурдъя.

1.1. Судалгааны зорилго, зорилт

Тус судалгааны зорилго нь эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд хэрэглэгдсэн холбох үгийн утга, үүрэг, хэрэглээний онцлогийг жишээ баримтад тулгуурлан тогтоож, тэдгээрийн өгүүлэмжийн болон найруулгыг үүрэг ба хэрэглээний үүднээс тайлбарлах, холбох үгийн ангилал, хэрэглээний ялгааг тодорхойлох, руни бичгийн дурсгалын учир зүйн бүтэц, өгүүлэмжийн зохион байгуулалтад гүйцэтгэх үүргийг илрүүлэхэд оршино.

Үүний тулд,

- Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд хэрэглэгдсэн холбох үгсийг цуглуулж, жишээ баримтаар бүрдүүлэх;
- Холбох үгсийн утга, хэл зүйн үүрэг, хэрэглээний онцлогийг дурсгал бүрийн хүрээнд задлан шинжлэх;
- Холбох үгийн үүрэг, харьцаа заах шинжээр нь ангилах;
- *tiyin/täyin, tip, anta kisrä, anta ötrü* зэрэг нийлмэл бүтэц бүхий холбох үгсийн хэрэглээ, давтамж, найруулгын үүргийг тодорхойлох;
- Судалгааны үр дүнд тулгуурлан холбох үгийн орчуулга, тайлбарын онол-практикийн ач холбогдлыг тодорхойлох зэрэг зорилт дэвшүүлсэн болно.

1.2. Судалгааны арга

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалын холбох үгийг хам цаг (*synchrony*)-ийн үүднээс судалсан бөгөөд утга, үүрэг, хэрэглээний онцлогийг жишээ баримтад тулгуурлан хэл зүйн хэлбэрээс гадна өгүүлэмж, найруулгын түвшинд гүйцэтгэх үүргээр нь тодорхойлох, өгүүлбэр хоорондын учир зүйн уялдаа, өгүүлэмжийн дараалал тогтоох үүргийг илрүүлэхэд дискурсийн шинжилгээний арга, Түрэг болон Уйгурын үеийн руни бичгийн дурсгал дахь холбох үгийн хэрэглээний давтамжийг тогтооход статистик тоон шинжилгээний арга зэргийг хэрэглэснээс хэл шинжлэлийн ухааны задлан шинжлэх (*analysis*), нэгтгэн дүгнэх (*synthesis*) нийтлэг арга баримтлав. Эдгээр аргуудыг хослуулан хэрэглэснээр эртний түрэг хэлний холбох үгийг хэл зүйн төдийгүй найруулга, өгүүлэмжийн түвшинд цогцоор нь авч үзэх боломжтой гэж үзэв.

1.3. Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Түрэгийн хожуу хаант улсын үеийн Күлтигин, Билгэ хаан, Туньюкук, Күличурын болон Онгийн гэрэлт хөшөөний бичээс, Уйгур улсын үеийн Шинэ

усны Моюн (Баян) чурын, Тариатын, Тэсийн гэрэлт хөшөө зэрэг руни бичгийн сонгодог дурсгалуудыг эх хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

Энэхүү судалгааны шинэлэг тал нь эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд хэрэглэгдсэн холбох үгийг зөвхөн уламжлалт хэл зүйн ангиллын хүрээнд авч үзэхээс зайлсхийж, тэдгээрийн найруулгын болон өгүүлэмжийн үүргийг голлон судалсанд оршино. Өмнөх судалгаанд холбох үгийг ихэвчлэн хэлбэр зүй, гарал үүсэл, ерөнхий утгын тайлбарын түвшинд авч үзэж ирсэн бол уг өгүүлэлд тэдгээрийн өгүүлбэр хоорондын учир зүйн уялдаа, өгүүлэмжийн дараалал тогтоох үүргийг жишээ баримтад тулгуурлан тодорхойлохыг хичээснээрээ онцлог юм.

Мөн руни бичгийн дурсгалын хүрээнд холбох үгийг зэрэгцүүлэн холбох болон захируулан (угсруулан) холбох гэсэн хоёр үндсэн ангиллын хүрээнд хэрэглээний давтамж, утгын ялгааг тодруулсан нь өмнөх судалгаанд төдийлөн тусгагдаагүй шинэ хандлага болно.

Холбох үгийн үүргийг ангилж тодорхойлсноор өгүүлбэр хоорондын шалтгаан, үр дагавар, цаг хугацаа, дарааллын харьцааг илүү оновчтой сэргээх боломж бүрдэж, улмаар орчуулгын алдаа, утгын зөрүүг багасгахад чухал хувь нэмэр оруулах боломжтой юм. Руни бичгийн сонгодог дурсгал болон болон уйгур, согд, брахма, манихейн олон зүйл үсэг бичгээрх эртний түрэг хэлний сурвалжууд, мөн түүнчлэн Османы турк хэлний болон орчин үеийн түрэг хэлнүүдийн холбох үгийг тогтолцоотой харьцуулж судлахад эх хэрэглэгдэхүүн болохын хувьд практик ач холбогдолтой болно.

2. Эртний түрэгийн руни бичгийн хэлний холбох үг

Эртний түрэг хэлний холбох үгийн судалгаанд ном судрын буюу бичмэл сурвалжийг ихэвчлэн эх хэрэглэгдэхүүнээр ашигласан байх бөгөөд руни бичгийн сонгодог болон бага бичгийн дурсгалын холбох үгийг анхаарч судалсан нь тун ховор ажээ. Тодруулбал, руни бичгийн дурсгалыг тухайлсан судалсан эрдэмтдийн бүтээлд дурдагдсанаас бус, эртний түрэг хэлний холбох үгийн судалгааны эх хэрэглэгдэхүүн, баримт болгон ашигласан, цуваа цагийн үүднээс утга, хэрэглээнд гарсан өөрчлөлт, хувьсал зэрэг түүхэн хөгжлийн зүй тогтлыг системтэйгээр харьцуулж судалсан судалгаа харьцангуй цөөн байна.

Гэрэлт хөшөө, хад чулуунд дурдатган өгүүлэгчийн санааг учир шалтгааны буюу учир зүйн алдаа мадаггүй, дэс дараатай, хураангуйлан товчоолж найруулан бичихэд холбох үг гол үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, салангид өгүүлбэр болон өгүүлбэрийн гишүүдийг холбож утга санааг нь нэгтгэн зангидах үндсэн хэрэглүүр нь холбох үг юм.

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалуудад *artuqi* ᠠᠷᠲᠤᠭᠢ, *ašnuqi* ᠠᠰᠨᠠᠭᠢ, *azu* ᠠᠵᠤ, *bašlayu* ᠪᠠᠰᠯᠠᠶᠤ, *birlä* ᠪᠢᠷᠯᠠ, *kisrā* ᠬᠢᠰᠢᠷᠠ (~*käsra* ᠬᠠᠰᠢᠷᠠ), *tiyin* ᠲᠢᠶᠢᠨ (~*täyin* ᠲᠠᠶᠢᠨ), *taqi* ᠲᠠᠭᠢ, *tip* ᠲᠢᠫᠢ, *ötrü* ᠥᠲᠷᠦ, *udu* ᠤᠳᠤ, *ulayu* ᠤᠯᠠᠶᠤ, *ücün* ᠤᠴᠦᠨ, *yämä* ᠶᠠᠮᠠ гэх үгс холбох үгийн үүргээр тохиолдож байна.

Холбох үгийг үүрэг, харьцаа заах шинжээр нь зэрэгцүүлэн холбох үг, захируулах буюу угсруулан холбох үг гэж ангилдаг бөгөөд энэхүү ангиллыг баримталж эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалын холбох үгийг авч үзье.

azu ᠠᠵᠤ ‘эсвэл’ гэх үг эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбох үүргээр Күлтигиний гэрэлт хөшөөний өмнө талын 10-р мөр, Билгэ хааны гэрэлт хөшөөний хойд талын 7-р мөр тус тус нэг удаа тохиолдож байна. Жишээ нь,

:ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ
 :ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ

*yoq: cīyany: bodunuy: qop qubratdim: cīyany:
 bodunuy: bay qiltim: az bodunuy: ukūš: qiltim: azu bu
 sabimda: igid barju: -Үгээгүй ядуу ард иргэдийг бүгдийг
 нь цуглуулав би. Ядуу ард иргэдийг баян болгов би. Цөөн
 ард иргэдийг өнөр болгов би. Эсвэл, энэ үгэнд минь
 худал байна уу?.*

Эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалын холбох үгсийг ажиглан үзвэл, дээр дурдсан мэт дан холбох үгс байхаас гадна руни бичгийн дурсгал олон давтамжтай тохиолдох *anta kisrā* ᠠᠨᠲᠤᠬᠢᠰᠢᠷᠠ ‘түүний хойно, түүний дараа, тэгээд хойно нь’, *anta ötrü* ᠠᠨᠲᠤᠮᠤᠳᠤᠬᠢᠰᠢᠷᠠ ‘тэр үед, тэр цагт, түүнээс хойш’ гэх үгс өгүүлбэрт салангид бус, нийлмэл бүтэц бүхий холбох үгийн утга, үүргээр оржээ.

2.1.2. Өгүүлбэрийн гишүүдийг зэрэгцүүлэн холбох үг

Түрэгийн руни бичгийн сонгодог дурсгалд арван гурван удаа, Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалд гурван удаа *anta kisrā* ᠠᠨᠲᠤᠬᠢᠰᠢᠷᠠ ‘түүний хойно, түүний дараа, тэгээд хожим’, *anta ötrü* ᠠᠨᠲᠤᠮᠤᠳᠤᠬᠢᠰᠢᠷᠠ ‘түүний дараа, тэгээд дараа нь’ гэх нийлмэл бүтэц бүхий үгс өгүүлбэрийн гишүүдийг зэрэгцүүлэн холбох үүргээр тохиолдож байна. Зэрэгцүүлэн холбох үг нь энгийн нийлмэл өгүүлбэр болон утгын холбоотой салангид өгүүлбэрүүдийг холбох үүрэгтэй.

Жишээ нь, Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 4-5 мөрд:

:ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ(5):ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ
 :ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ
 ↓ᠠᠨᠲᠤ

*anta käsrä: inisi qayan: bolmiš ärinč: oyliti: qayan bolmiš
 ärinč: anta käsrä: inisi: äčisin täg: qilinmaduq ärinč: oyli:
 qaḣin täg: qilinmaduq ärinč:*

Түүний дараа дүү нь хаан болсон ажээ. Хөвгүүд нь хаан болсон ажээ. **Тэгээд хожим** дүү нь ахын адил байсангүй ажээ. Хүү нь эцгийн адил байсангүй ажээ.

Могойн шинэ усны Моюн (Баян) чурын гэрэлт хөшөөний 12-р мөрд:

:ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ

anta: käsrä: qaḣim qayan: učdi: Түүний хойно эцэг хаан минь халив.

Тариатын гэрэлт хөшөөний өмнө талын 3-р мөрд:

:ᠡ᠋ᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨᠠᠵᠤᠨᠢᠨᠬᠡᠳᠤᠰᠡᠪᠠᠯᠢᠨᠦᠨ

anta käsr[ä] [i]t yiliqa üč qarluq yablaq šaqinip täzä bardī **Түүний дараа** нохой жил (746)-д гурван Карлук муу санаж зугтан одов.

anta ötrü 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 ʼтүүний дараа, тэгээд дараа ньʼ гэх нийлмэл бүтэц бүхий үг эртний түрэг хэлний сонгодог дурсгалд тун цөөн удаа холбох үгийн үүргээр тохиолдож байна. Үүнд, Туньокукын гэрэлт хөшөөнд хоёр удаа, Могойн шинэ усны Моюн (Баян)чурын гэрэлт хөшөөний бичээст нэг удаа тус тус тэмдэглэгджээ.

Жишээ нь, Туньокукын гэрэлт хөшөөний 12-р мөрд:
 :𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣

anta ötrü: qayanïma ötüntüm: Тэгээд дараа нь хаандаа өчив би.
 Туньокукын гэрэлт хөшөөний 16-р мөрд:

𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣
anta ötrü: oγuz qopïn: kälti: Тэгээд дараа нь Огузууд бүгдээр ирэв.

Моюн чурын гэрэлт хөшөөний өмнө талын 5-р мөрд:
 :𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣

anta: ötrü: türgis: qarluqïγ: tabarïn: alïp: äbin: yulïp: barmïš:

Тэгээд дараа нь Түргиш, Карлукын эд барааг нь авч, гэрийг тонож оджээ.

2.2. Захируулан холбох үг

Гол үгийн дараа орж тухайн үгээ дараагийн үгтэй холбох харьцаа заадаг үгийг захируулан холбох үг гэх ба уг үг нь нэр үгийг нэр ба үйл үгэнд, үйл үгийг үйл ба нэр үгэнд захируулан холбоно. Захируулан холбох үг нь үгийн сангийн утгаа бүрэн алдаагүй учраас утгаар нь ангилах боломжтой юм (МХС, Үг зүй, 2022: 179-180).

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалын захируулан холбох үүргээр орсон үгсийг зорилго, шалтгаан заасан, тоо хэмжээ, баримжаа заасан, жишиж адилтгасан, орон байр заасан, цаг хугацаа заасан захируулан холбох үг хэмээн ангилж болохоор байна.

2.2.1. Зорилго, шалтгаан заасан захируулан холбох үг

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалуудад 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 *üčün* ‘тул’, 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 *birli* ‘хамт’ гэх үг зорилго, шалтгаан заасан захируулан холбох үгийн үүргээр тохиолдож байна. Жишээ нь, Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 6-р мөрд:

𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣
 :𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣
 :𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣
 :𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣
 :𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣 𐰇𐰏𐰣𐰤𐰡𐰣

*bägläri: boduni: tüzsüz üčün: tabγaç bodun: täbligün:
 körlüg: üčün: armaqčësin: üčün: inili: äçili: kiksürtükün: üčün:
 bägli: bodunlïγ: yoγaşurtuqïn: üčün türük: bodun: illädük: ilin:
 ičγïnu: idmïš:*

Ноёд нь, ард зон нь шударга бус тул, Табгач ард зон ов мэхтэй, арга зальтай тул хуурамч худалч тул ах дүүсийг эвдрэлцүүлсэн тул, ноёдтой

ᠠᠵᠢ ᠤᠯᠠᠭᠢᠨᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ
äki ülägi: atliy ärti: bir ülägi: yaday ärti:
 Хоёр хэсэг нь морьтой, нэг хэсэг нь явган байв.

2.2.3. Жишиж адилтгасан захируулан холбох үг

Нүүдэллэн аж төрөх ард түмний амьдралын онцлогоос хамаарч байгалийн болон амьтны хэв шинж хийгээд ер сав шим ертөнцийн аливаа юмс үзэгдэл, дүр байдлыг төрх байдалтай жишиж адилтган өгүүлэх, бичих нь түгээмэл бөгөөд тэрхүү адилтгал, зүйрлэл нь түүхэн урт хугацааны явцад хэлц, хэллэг болж уламжлагддаг.

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд *ᠬᠠᠮᠤᠳᠤᠭ* ‘мэт, шиг’ гэх жишиж адилтгасан холбох үг тохиолдож байна. Жишээ нь, Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 5, 6-р мөрүүдэд:

ᠰᠢᠨᠵᠢᠨᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ
 :ᠰᠢᠨᠵᠢᠨᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ
 :ᠰᠢᠨᠵᠢᠨᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ

oyliti: qayan bolmiš ärinč: anta käsrä: inisi: äčisin täg: qilinmaduq ärinč: oylī: qañin täg: qilinmaduq ärinč:

Хөвгүүд нь хаан болсон ажээ. Тэгээд хойно нь дүү нь ахын адил бүтээсэнгүй ажээ. Хүү нь эцгийн адил бүтээсэнгүй ажээ.

Энэхүү эхэд *ᠬᠠᠮᠤᠳᠤᠭ* ‘мэт, шиг’ холбох үгийн тусламжтайгаар дүүг ахтай нь, хүүг эцэгтэй нь жишин адилтгаснаар Билгэ хаан өөрийн эцэг Ил тириш хааныг гавьяа зүтгэлтэй харьцуулж, түүний дүү авга ах Капган хаан болон авга ач нар болох түүний хөвгүүдийг хаан ширээнээс зайлуулсан үйл хэргээ тун цөөн үгээр зөвтгөн тайлбарласан байна.

Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 12, 11-р мөрүүдэд:

ᠲᠠᠭᠢᠨᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ
täñri: küč: birtük: üčün: qañim qayan: süsi: böri täg: ärmiš: yayisi: qony täg ärmiš:

Тэнгэр хүч өгсөн учир, эцэг хааны минь цэрэг нь чоно мэт байжээ. Дайсан нь хонь мэт байжээ.

Хаан эцгийнхээ цэргийн сүр хүчийг чонотой, дайсныг хоньтой зүйрлэж адилтгасан нь мал аж ахуйтай ард түмний соёлын сэтгэлгээний нийтлэг хэв шинжийг илтгэж байна.

Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалуудаас Тариатын гэрэлт хөшөөний хойд талын 1-р мөрд:

ᠲᠠᠭᠢᠨᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ ᠠᠲᠤᠯᠦᠭᠤᠨᠠᠵᠢ
täñgrim qanīm: tämi[r?] täg älig: tutun [bärti]

Тэнгэр минь, хан эцэг минь төмөр мэт улсыг захирч [өгөв] гэж буй.

Хэдийгээр *ᠬᠠᠮᠤᠳᠤᠭ* *tämi[r?] täg* ‘төмөр мэт’ гэдэг нь эргэлзээтэй боловч хамгийн бат бэх улсыг, төрийг ‘төмөр’-тэй зүйрлэсэн байх бүрэн боломжтой юм.

2.2.4. Орон байр заасан захируулан холбох үг

tägi ‘хүртэл’ гэх орон байр заасан захируулан холбох үгийг хэрэглэсэн байна. Күлтигиний гэрэлт хөшөөний өмнө талын 3-4 дүгээр мөрд:

:μΥ€ΥΠΔ:※※ЄН:ЄΛΠΥ:ΠНДГД:※×ΥМ:ПЄНΠНЧД:ΥΘΥ:ΠΥЄΥΠ
:ЧЄММЗЗ:γДГГДГ↓:※×※ЄН:ЄΛΠΥ:ΠНМММН:※×ΥМ:ПЄН:ΠНММММ:ЧГ↓Д
:※×ΥМ:ПЄН:ΠНΥΠΥГ:γ↓ДДΥГ:γДГГГГ:※×ΥМ:ПЄН:ΠНММММ:※Н:ΠЛГ
:※※ДД:ПЄН:ΠНΥΠΥГ:ΠЗЗД

ilgärii: šantuŋ: yazıqa tügeni: sülädim: taluyqa: kičig: tägmädim: birgärii: toquz: ärsinkä: tügeni: sülädim: tüpütkä: kičig: tägmädim: qurıyaru: yänču ügüz (4)käčä: tämir qapıyqa: tügeni: sülädim: yirıyaru: yär bayırqu: yiriñä: tügeni: sülädim: bunča: yirkä: tügeni: yoritdim. Дорно зүг Шантунгийн тал **хүртэл** цэрэглэв би. Далайд хараахан хүрсэнгүй би. Өмнө зүг Есөн Эрсүн **хүртэл** цэрэглэв би. Төвдөд хараахан хүрсэнгүй би. Өрнө зүг Сувдан (Сыр дарьяа) мөрнийг (4) гаталж Төмөр хаалга **хүртэл** цэрэглэв би. Умар зүг талын Байрку, тэдний газар нутагт **хүртэл** цэрэглэв би. Ийм их хол газар нутагт **хүртэл** явав би.

ПЗП↓ *qudi* ‘дагуу, уруудан’ гэсэн холбох үг Билгэ хаан, Ту Ньюкукийн гэрэлт хөшөөнд, мөн Шинэ усны буюу Уйгурын Моюн (Баян) чурын гэрэлт хөшөөний бичээст тус тус нэг удаа тохиолдоно.

Жишээ нь, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 37-р мөрд:
:※※ЧГДЛГ:ММНМД:МНΔ:ГДГГГГ:ДГГН:ДГМД:ПЗП↓:ΠΥΠ
sälänjā: qudi: yorıpan: qarayān: qışilta: äbin: barqin: anta buzdum. Сэлэнгэ **уруудан** явахдаа Харгана [qarγan-a] хясаа дахь гэрийг нь, сүмийг тэнд эвдэв би.

Ту Ньюкукийн гэрэлт хөшөөний 27-р мөрд:
:Ч※※МД:ПЗП↓ДГГГГГГ:ПЗП]※МД:ПНДГГГГГ
anı sub[qa] bardı[miz]: ol sub qudi: bardimiz:

Аны усанд (голд) хүрэв бид. Тэр голын **уруудан** явж хүрэв бид. Моюн (Баян) чурын гэрэлт хөшөөний бичээсийн зүүн талын 4-р мөрд:

:ПМД:ПЗПН:ΠΥΠ:ΠММ
üküsi sälänjā qudi bardı

Олонх нь Сэлэнгийг уруудан хүрэв.

Түрэгийн үеийн руни бичгийн дурсгалд ПЗП↓ *qudi*, Уйгурын үеийн дурсгалд ПЗПН *qudi* гэж ↓ *qu*, П *q* гэх нэг үсгийн хоёр өөр тэмдэгтийг хэрэглэсэн нь аялгууны хувьд түрэгүүд *qudi* гэж уртаар дуудаж хэлдэг байсны нэг жишээ хэмээн үзэж болно.

2.2.5. Цаг хугацаа заасан захируулан холбох үг

Эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд γДΥД *bašlayu* ‘эхэлж, түрүүлж’ гэх үг холбох үгийн үүргээр Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээст тус тус хоёр удаа тохиолдож байна. Жишээ нь, Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 16, 13 дугаар мөрд:

:ПЗПН:ДДГД:ГДГНЧД:γДΥД:ΠНГН:※ΠН
qanım: qayanqa: bašlayu: baz qayanıy: balbal: tikmiš:

Хаан эцэгт минь түрүүлж Баз хааны балбал босгожээ.

Күлтигин, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 25, 20 дугаар мөрд:
:※×ПН:ДДГД:ГДГНЧНЧД:γДΥД

başlayu: qırqız qayanıy: balbal: tikdim:

Түрүүлж Киргиз хааны балбал босгов би.

Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалуудад 𐰉𐰏𐰤𐰢 *başlayu* ‘эхэлж, түрүүлж’ гэх үг болон цаг хугацаа заасан захируулан холбох үг тохиолдохгүй байна.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалд хэрэглэгдсэн холбох үгийн утга, үүрэг, хэрэглээний онцлогийг жишээ баримтад тулгуурлан тогтолцоотой авч үзэхэд, холбох үг нь зөвхөн өгүүлбэр, өгүүлбэрийн гишүүдийг хэл зүйн хувьд холбох хэрэгсэл бус, харин дурсгалын утга санааг учир зүйн дэс дараалалтай, шалтгаан холбоотой, найруулгын хувьд нягт, товч илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь ажиглагдаж байна.

Руни бичгийн сонгодог дурсгалууд нь хад чулуу, гэрэлт хөшөөнд сийлсэн, хэл найруулгын хувьд хураангуй, өгүүлэмжийн нарийн дараалал шаардлагатай бичгийн төрөл тул өгүүлбэрүүдийн хоорондын утгын уялдаа, учир зүйн холбоог холбох үгээр дамжуулан илэрхийлэх нь зайлшгүй хэрэгцээ байжээ. Иймд холбох үгийг зөв ойлгож, зөв орчуулан тайлбарлах нь дурсгалын түүхэн агуулга, өгүүлэгчийн санаа зорилгыг гажуудалгүй сэргээн тогтоох ач холбогдолтой юм.

Эртний түрэг хэлний руни бичгийн дурсгалд холбох үгийг үүрэг, харьцаа заах шинжээр нь үндсэндээ зэрэгцүүлэн холбох үг болон захируулан (угсруулан) холбох үг гэж ангилж болно. Зэрэгцүүлэн холбох үг нь өгүүлбэрийн гишүүд, энгийн нийлмэл өгүүлбэр, утгын холбоотой салангид өгүүлбэрүүдийг холбох үүргээр хэрэглэгдсэн бол захируулан холбох үг нь гол үгийн дараа орж, зорилго, шалтгаан, цаг хугацаа, орон байр, тоо хэмжээ, баримжаа, жишиж адилтгасан зэрэг олон төрлийн утгын харьцааг илэрхийлж байна. Тухайлбал, *tiyin/täyin, tip* зэрэг холбох үгс өгүүлбэрийн гишүүдийг зэрэгцүүлэн холбохдоо хэл найруулгад онцгой идэвхтэй хэрэглэгдэж, ялангуяа Түрэгийн үеийн руни бичгийн дурсгалд давамгайл байр суурь эзэлж байсан нь давамжаас харагдана.

Харин Уйгурын үеийн руни бичгийн дурсгалд эдгээр холбох үгийн зарим нь хэрэглэгдэхгүй болсон нь хэл найруулгын хэв маяг, хэрэглэгдэхүүнд гарсан өөрчлөлтийг илтгэх чухал баримт юм.

Мөн *anta kisträ, anta ötrü* зэрэг нийлмэл бүтэц бүхий холбох үгс нь дан ганц цаг хугацааны утга заахаас гадна өгүүлэмжийн дарааллыг тогтоож, үйл явдлыг логик учир зүйн залгамж холбоотойгоор өрнүүлэх найруулгын чухал хэрэгсэл болж байгаа нь жишээгээр батлагдаж байна. Энэ нь эртний түрэг хэлэнд холбох үгийн тогтолцоо нь бүтэц, утгын хувьд нэлээд баялаг, хөгжсөн байсныг илтгэнэ.

Эртний түрэг хэлний холбох үгсийн ихэнх нь язгуур утгаа бүрэн алдаагүй, дайвар үг, дагавар үг, нөхцөлт үйл үгийн хэлбэрээс үүсэлтэй бөгөөд хэрэглээний явцад өгүүлбэр холбох тусгай үүрэгтэй болсон нь тодорхой байна.

Эцэст тэмдэглэхэд, эртний түрэг хэлний руни бичгийн сонгодог дурсгалын холбох үгийн судалгаа нь зөвхөн хэл зүйн ангиллын асуудал бус, тухайн үеийн бичгийн соёл, сэтгэхүйн учир зүйн бүтэц, өгүүлэмжийн арга барилыг тодруулахад чухал ач холбогдолтой юм. Цаашид руни бичгийн сонгодог болон бага бичгийн дурсгалууд, бичмэл сурвалжуудын холбох үгийг харьцуулан

судлах, мөн Уйгурын үеэс хойших хэл найруулгын өөрчлөлттэй уялдуулан авч үзэх нь эртний түрэг хэлний түүхэн хөгжил, хэл зүйн хувьслыг илүү гүнзгий тайлбарлах боломж бүрдүүлэх нь дамжиггүй юм.

Санхүүжилт: Тус өгүүлийг ШУТС-аас санхүүжүүлж буй “Алтайн хэлнүүдийн хэл зүйн харьцуулсан судалгаа-Туслах үгийн аймгийн жишээгээр” (зөвшөөрлийн дугаар: ШУСс-2024/22) суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Ном зүй

- Айдаров, Г.** (1971). *Язык Орхонских памятников древнетюркской письменности VIII века*. Алма-Ата. [Aidarov, G. *The language of the Orkhon monuments of Old Turkic writing of the 8th century*. Alma-Ata, 1971]
- Базаррагчаа М., Зэгиймаа Ч.** (2014). *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар. [Bazarragchaa M., Zegiimaa Ch. *Khel shinjleliin ner tomionyon tailbar toli* [An Explanatory Dictionary of Linguistic Terms]. Ulaanbaatar, 2014]
- Кондратьев, В. Г.** (1981). *Грамматический строй языка древнетюркской письменности VIII-XI вв.* Ленинград. [Kondratyev, V. G. (1981). *The Grammatical Structure of the Language of Old Turkic Written Monuments of the 8th-11th Centuries*. Leningrad. 1981]
- Өнөрбаян Ц.** (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар. [Unurbayan, Ts. *Orchin tsagyn mongol khelnii üg züi* [Morphology of the Modern Mongolian Language]. Ulaanbaatar, 2004]
- Радлов, В. В.** (1892a). *Атласъ древностей Монголии*. Фото Вас. Остр., 9 лин., №12. Труды Орхонской экспедиции. Санктпетербургъ: Типографія Императорской Академіи Наукъ. [Atlas of the Antiquities of Mongolia. Photo by Vas. Ostr., 9th line, No. 12. Works of the Orkhon Expedition. Saint Petersburg: Printing House of the Imperial Academy of Sciences. 1892]
- Радлов, В. В.** (1892b). *Предварительный отчет о результатах снаряженной с Высочайшего соизволения Императорской Академией Наук экспедиции для археологического исследования р.Орхона*. Vol. Вып.1. Сборник Труды Орхонской экспедиции I. Санкт-Петербург. [Preliminary Report on the Results of the Expedition Commissioned by the Highest Permission of the Imperial Academy of Sciences for the Archaeological Study of the Orkhon River. Vol. 1. Collection: Works of the Orkhon Expedition I. Saint Petersburg, 1892]
- Төмөртоого Д.** (2004). *Хэлшинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*. Улаанбаатар. [Tumurtogoo, D. *Khel shinjleliin ner tomioony khuraangui toli* [Concise Glossary of Linguistic Terms]. Ulaanbaatar, 2004]
- Өнөрбаян Ц., Жумдаан Л., Саруул-Эрдэнэ М., Ганбаатар Ж.** (2022). *Монгол хэл судлал-Үг зүй*. IX боть. Улаанбаатар. [Unurbayan Ts., Jumdaan L., Saruul-Erdene M., Ganbaatar J. *Mongol khel sudlal-Üg züi* [Mongolian Linguistics – Morphology]. Ulaanbaatar. 2022]
- Ядринцев, Н. М.** (1901). *Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году*. Сборник трудов Орхонской

- экспедиции V. Санкт-Петербург. [*Report and Journal of the Journey along the Orkhon River and to the Southern Khangai in 1891*. Collection of Works of the Orkhon Expedition, Vol. V. Saint Petersburg, 1901]
- Ядринцев, Н. М.** (1892). *Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889г. Поручению Восточно-Сибирского Отд. Географического Общества*. Сборник трудов Орхонской экспедиции I. Санкт-Петербург. [*Report of the Expedition to the Orkhon, Carried Out in 1889 by Order of the East Siberian Branch of the Geographical Society*.] Collection of Works of the Orkhon Expedition, Vol. I. Saint Petersburg, 1892]
- Ercilasun Ahmet Bican**, (2004). *Başlangıçtan Yirminci Yüzyıla Türk Dili Tarihi*, Ankara, s.193
- Erdal, Marcel** (2004). *A Grammar of Old Turkic*, Leiden Brill.
- Heikel, Axel O., Georg Gabelentz, Gabriel Devéria, and Otto Donner.** (1892). *Inscriptions de l'Orkhon: recueillies par l'expédition Finnoise 1890*. Helsingfors: Société finno-ougrienne.
- Korkmaz, Zeynep** (2003). *Türkiye Türkçesi Grameri (Şekil Bilgisi)*, Ankara.
- Radloff, Wilhelm** (1894). *Die alttürkischen Inschriften der Mongolei* (version Neue Folge 1897; Zweite Folge 1899 (in 2 vols: Otto Zeller Verlag, Osnabrück 1987)). Neue Folge 1897; Zweite Folge 1899 (in 2 vols: Otto Zeller Verlag, Osnabrück 1987). St. Petersburg.
- Şirin, Hatice** (2016). *Eski Türk Yazıtları. Söz Varlığı İncelemesi*, Ankara.
- Tekin, Talat** (1968). *A Grammar of Orkhon Turkic*, Indiana University Publications, Bloomington.
- Tekin, Talat** (2000). *Orhon Türkçesi Grameri*, İstanbul.
- Temir, Ahmet** (1956). *Die Konjunktionen und Satzeinleitungen im Alt-Türkischen I, II*, Oriens IX. Leiden.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>